

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2018.07.27

Улаанбаатар хот

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

2.1.Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 70 хуулийн 392 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 78 хуулийн 197 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 26 хууль буюу 33.3 хувь, 105 хэсэг, заалт буюу 26.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 56 /давхардсан тоогоор/ хуулийн 287 хэсэг, заалт буюу 73.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 14 хуулийн 18 хэсэг, заалтыг хяналтаас хассан тухай мэдээг ирүүлж, өмнөх онуудад хяналтаас хасагдсан 49 хуулийн 74 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	392
2	Засгийн газраас ирүүлсэн	78	197
	Үүнээс:		
-	Хяналтанд байгаа	26	105
-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас	49	74

	хассан		
	- 2017 оны хагас жилээр хяналтаас хасагдсан	14	18
3	Засгийн газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	56	287

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 26 хуулийн 105 хэсэг, заалтаас 13 хуулийн 23 хэсэг, заалт буюу 21.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 11 хэсэг, заалт буюу 10.5 хувь нь хэрэгжих шатанд, 23 хуулийн 58 хэсэг, заалт буюу 55.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 12 хэсэг, заалт буюу 11.4 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 9 хуулийн 57 хэсэг, заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн мэдээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 6 хуулийн 18 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 3 хуулийн 39 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 6 хуулийн 18 хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл, 1 хуулийн 2 хэсэг, заалт буюу 11.1 хувь нь хэрэгжсэн, 1 хуулийн 2 хэсэг, заалт буюу 11.1 хувь нь хэрэгжих шатанд, 6 хуулийн 14 хэсэг, заалт буюу 77.8 хувь нь хэрэгжээгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	57	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	6	18	31.6
Үүнээс:			
- Хэрэгжсэн	1	2	11.1
- Хэрэгжих шатанд байгаа	1	2	11.1
- Хэрэгжилт хангалтгүй	6	14	77.8
- Зөрчилтэй	-	-	-

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 6 хуулийн 18 хэсэг, заалтаас дараах 4 хуулийн хэрэгжилтийн явц, үр дүн нь 2017 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн мэдээнээс буурч ирсэн байна. Үүнд:

- **Усны тухай хуулийн** /шинэчилсэн найруулга/ 10.1.10-т заасан “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах” гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй болсон;
- мөн хуулийн 24.7-т заасан “Энэ хуулийн 24.2-т заасан “хаягдал ус хаях,

- зайлуулах зөвшөөрлийн бичгийн загварыг байгаль орчны болон хот, суурины усан хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй болсон;
- 31.2-т заасан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.” гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй болсон;
 - **Ус бохирдуулсны төлбөрийн тухай** хуулийн 6.2-т заасан “Хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горимыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно” гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй болсон;
 - **Хүнсний тухай хуулийн** 6.2-т заасан “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална /6.1-т Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ/ гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй болсон;
 - **Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай** хуулийн 9.5-д заасан “Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн хэсгийн хэрэгжилт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 70 хувь болон хэрэгжилтийн хувь буурсан байна.

ГУРАВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1.Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 171 заалтыг хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 45 тогтоолын 106 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 20 тогтоолын 48 заалт буюу 28.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 57 /давхардсан тоогоор/ тогтоолын 123 заалт буюу 72.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 17 тогтоолын 27 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 31 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 20 тогтоолын 48 заалтаас 11 тогтоолын 18 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10 тогтоолын 22 заалт буюу 45.8 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 4.3 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 9 тогтоолын 12 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 2 тогтоолын 4 заалт буюу 33.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 7 тогтоолын 8 заалт буюу 66.6 хувийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 2 тогтоолын 4 заалтын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл, давхардсан тоогоор 2 тогтоолын 2 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжсэн, 1 тогтоолын 2 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжих шатанд байна.

	УИХ-ын тогтоол	Заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	9	12	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	2	4	33.4
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	2	50.0
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	2	50.0

3.3.Мэдээнд гарсан зөрчил

“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолын 2.5-т “*малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох*” заалтын хувьд 2016 оны жилийн эцсийн мэдээнд 90 хувийн хэрэгжилттэй гэж ирүүлж байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 70 хувь болгож, хэрэгжилтийн үнэлгээг бууруулсан байна.

ДӨРӨВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1.Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 100 тогтоолын 544 заалтыг хяналтанд авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 46 тогтоолын 186 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэнээс, хяналтанд байгаа 36

тогтоолын 124 заалт буюу 22.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 81 /давхардсан тоогоор/ тогтоолын 420 заалт буюу 77.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 36 тогтоолын 124 заалтаас 18 тогтоолын 41 заалт буюу 33 хувь нь бүрэн хэрэгжсэн, 21 тогтоолын 53 заалт буюу 42.7 хувь нь хэрэгжих шатанд, 14 тогтоолын 23 заалт буюу 18.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.8 хувь нь хэрэгжээгүй, 5 тогтоолын 6 заалт буюу 5 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн онуудад хяналтаас хасагдсан 13 тогтоолын 29 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 33 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 11 тогтоолын 44 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэгдэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 4 тогтоолын 8 заалт буюу 18.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 7 тогтоолын 36 заалт буюу 81.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн тус Байнгын хорооны 4 тогтоолын 8 заалтын хэрэгжилтийн явцыг авч үзвэл, давхардсан тоогоор 2 тогтоолын 3 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 3 заалт буюу 37.5 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 2 заалт буюу 25.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БОХХААБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	11	44	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	4	8	18.2
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	3	37.5
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	3	37.5
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	2	25.0

4.3. Мэдээнд гарсан зөрчил

БОХХААБХ-ны “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 07 тоот тогтоолын 1.1-т “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, статусыг тодорхой болгох, нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг давуу эрхтэйгээр ашиглах, байгаль хамгаалахад зарцуулсан зардлыг байгалийн нөөцийн төлбөрийн

орлогоос буцаан олгох замаар нөхөрлөлийн санхүүгийн тогтвортой механизмыг бий болгох чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах” гэсэн заалтын хэрэгжилтийг 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй гэж ирүүлж байсан бол 2017 оны жилийн эцсийн мэдээнд хэрэгжилтийн хувийг бууруулан 30 хувь болгон ирүүлсэн байна.

ТАВ.БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 1 хуулийн 2 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 2 тогтоолын 2 заалт, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2 тогтоолын 3 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Хууль тогтоомжийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын хууль	1	2
Улсын Их Хурлын тогтоол	2	2
Байнгын хорооны тогтоол	2	3

ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд шинжилгээ хийхэд өмнөх онуудад бүрэн хэрэгжсэн, хасах саналтай ирүүлж байсан хууль тогтоомжийг дахин ирүүлэх, хяналтанд байгаа хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг ирүүлэлгүй орхигдуулах, хэрэгжилтийн мэдээг өөрчлөлтгүй ирүүлэх зэрэг нийтлэг алдааг хянаж, цаашид эдгээр алдааг гаргахгүй ирүүлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн хэрэгжилтийг тооцохдоо хяналт-шинжилгээ хийж, үнэлэлгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлалгүй өмнөх ирүүлсэн хэрэгжилтийн мэдээг хуулбарлан ирүүлэх зөрчил байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байх зэрэг нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЖАГСААЛТ
/2017 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Усны тухай /шинэчилсэн найруулга/ 2012.05.17	<p>4.8 Сав газрын менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>4.9 Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар /цаашид “сав газар” гэх/ бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.</p>	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрийг нийт 29 сав газарт хуваасан бөгөөд өнөөдрийн байдлаар 17 сав газрын УННМТ (Туул гол, Орхон гол, Онон гол, Хар нуур-Ховд гол, Хяргас нуур-Завхан гол, Улз гол, Хөвсгөл нуур-Эгийн гол, Идэр гол, Бөөнцагаан нуур-Байдраг гол, Буйр нуур-Халх гол, Онги гол, Хануй гол, Увс нуур-Тэсийн гол, Сэлэнгэ гол, Ерөө гол, Дэлгэрмөрөн гол, Хэрлэн гол зэрэг)-г байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлаад байна. 2017 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-өөр 3, Дэлхийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2, ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яамнаас хэрэгжүүлж буй Төв Азийн усны нөөцийн нэгдсэн менежментийн загвар бүс нутаг “МоМо” төслийн хүрээнд 1, нийт 8 сав газрын УННМТ (Таац гол, Орог нуур-Түйн гол, Шишхэд гол, Хүйсийн говь-Цэцэг нуур, Хараа гол, Умард говийн гүвээт-Халхын дундад талын, Галба-Өөш, Долоодын говийн, Алтайн өвөр говийн)-г боловсруулах хөрөнгийг шийдвэрлэн ажиллаж байна.УННМТ-ний суурь судалгаа хийх хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй 4 (Мэнэнгийн тал, Чулуут гол, Үенч-Бодонч гол, Булган гол) сав газар байна. Энэхүү ажлын хэрэгжилт тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай байна.</p> <p>Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (УННМТ)-г гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарт үндэслэн боловсруулж баталгаажуулан хэвшсэн.</p>
Нийт 1 хуулийн 2 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p>Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай</p> <p>2012.12.28 №74</p>	<p>2.4 Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үйлдвэрлэгчид олгох зээлийн хүүг жилийн 7 хувиас илүүгүй байхаар тооцож олгох; ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах.</p>	<p>УИХ-ын 2012-12-28-ны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74-р тогтоолоор “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулж 140,4 тэрбум /нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаас гаргаж арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн.</p> <p>Засгийн газрын 2013 оны 48-р тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, тайлагнах журам” батлуулсан.</p> <p>Мөн Засгийн газрын 2014 оны 198-р тогтоол, 2014 оны 217-р тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд олгох эх үүсвэрийг нийт 140,4 тэрбум (нэг зуун дөчин тэрбум дөрвөн зуун сая) төгрөгөөр баталж, Хөгжлийн банктэй дамжуулан зээлдэх нөхцөлийг зөвшөөрч гэрээ байгуулсан арилжааны банкуудаар дамжуулан жилийн 7 хувийн хүүтэй зээл олгохоор тогтсон бөгөөд арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдийн төсөлд 2014 оны 8-р сараас эхэлж, Хөгжлийн банкны санхүүжилтээр 9 арилжааны банкаар дамжуулан нийт 57 үйлдвэрт 86 тэрбум төгрөгийн зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон байна. 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 54,4 тэрбум төгрөгийг өөр зориулалтаар зарцуулсан гэх аман тайлбарыг Хөгжлийн банкнаас ирүүлж, 2016 оны 6-р сараас хойш арьс ширийг дотооддоо гүн боловсруулах үйлдвэрлэгч, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зээл олгогдоогүй болно.</p>
2	<p>Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай</p> <p>2016.05.19 №46</p>	<p>1.2 Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хэмжээ, хилийн зааг, мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа, тариалангийн технологи болон холбогдох бусад журмыг тогтоож, харьяалах төрийн</p>	<p>Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Халх гол сумын нутаг дэвсгэрт Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулж, улсын тусгай хэрэгцээнд авч байгаа газрын хэмжээ, хилийн заагийг тогтоосны зэрэгцээ бүсийн удирдлага, зохион байгуулалт болон газар ашиглалтын нийтлэг журмыг баталсан. Мөн энэхүү тогтоолоор бүсийн захиргааг байгуулан бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, захирлыг томилон үйл ажиллагааг эхлүүлэх, бүсийн захиргааны дүрмийг батлах, газрын ашиглалтын үйл ажиллагааг бодлого зохицуулалт, удирдамж, чиглэлээр хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад үүрэг болгосон.</p> <p>Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А-102 дугаар</p>

		захиргааны төв байгууллагад шилжүүлэх.	тушаалаар “Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Тариалангийн технологийн хувьд ХХАА-н Сайдын 2015 оны А-110 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан ХАА-н “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсэд дагаж мөрдөх тариалангийн үйлдвэрлэл эрхлэх журмыг дагаж мөрдөж байна.
Нийт 2 тогтоолын 2 заалтыг хяналтаас хасах саналтай байна.			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо,дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай 2014.01.15 №04</p>	<p>1.4 Ойн цэвэрлэгээ хийх газар нутгийн ойд замын хайгуул хийж зураг төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах ажлын зардлыг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>ХХААХҮЯ-аас 2014 онд 5 аймгийн 15 сумын ашиглалтын бүсийн ойн санд 370 км ойн төв зам байгуулах замын сүлжээний ерөнхий зураглал гаргаж, Сэлэнгэ аймгийн Мандал суманд 30 км ойн зам барих зураг, төсөв боловсруулсан. Тухайн оны Улсын төсөвт тусгахаар санал оруулсан боловч 2015 оны төсөвт дэмжигдээгүй. УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” болон Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрт ашиглалтийн ой бүхий нутагт ойн замын сүлжээг сэргээн өргөжүүлж, ойн нөөцийг иж бүрэн, зүй зохистой, тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжих зорилтыг тусгасан.</p> <p>Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойжуулах, замаар ойгоор бүрэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой тогтвортой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох зорилго бүхий “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ны 49 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус бодлогын баримт бичигт ашиглалтийн ой бүхий нутагт ойн замын сүлжээг сэргээн өргөжүүлж, ойн нөөцийг иж бүрэн, зүй зоистой, тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжих зорилтыг тусгасан.</p> <p>Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрт “Эмзэг экосистем бүхий ойд сөрөг нөлөөгүйгээр ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэн ойг эрүүлжүүлж, ойн төлөв байдлыг сайжруулан нөхөн сэргээх” зорилтын хүрээнд “ойн цэвэрлэгээ явуулах шаардлагатай бүсэд ойн замын хайгуул хийх, зураг төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах” үйл ажиллагааг тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p>

		<p>1.5 Мод модон материалын зах зээлийн хэрэгцээний тодорхой хэсгийг цэвэрлэгээнээс гарах бүтээгдэхүүнээр хангах замаар хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ авч ажиллах;</p>	<p>УИХ-ын 2015 оны 05-р сарын 14-ны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт</p> <p>1.Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хууль эрх зүйн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох;</p> <p>2.Иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг ойн арчилгаа, цэвэрлэгээний болон түүвэрлэх огтлолт зэрэг ойн экосистемд халгүй аргаар бэлтгэсэн модоор хангахаар зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.</p> <p>Дээрхи бодлогын зорилтууд жил бүрийн мод бэлтгэлийн дээд хэмжээг баталсан Сайдын тушаал шийдвэрт тусган хэрэгжүүлж, мод, модон материалын зах зээлийн эрэлт, хэрэгцээний тодорхой хэсгийг ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн модоор хангах, ингэснээр хууль бус мод бэлтгэлийг бууруулах зорилгоор “2015 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” БОНХСайдын 2014 оны А-382, “2016 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” БОНХАЖСайдын 2015 оны А/415, “2017 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” БОАЖСайдын 2016 оны А/111, “2018 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” БОАЖСайдын 2017 оны А/235 дугаар тушаалаар тус тус тухайн жилд ойн цэвэрлэгээгээр бэлтгэх модны хэмжээг баталсан.</p> <p>Ойн сан бүхий аймгууд ойн цэвэрлэгээр 2014 онд 200,0 мянган шоометр хэрэглээний мод, 594,8 мянган шоометр түлээний мод, 2015 онд 106,3 мянган шоометр хэрэглээний мод, 493,3 мянган шоометр түлээний мод, 2016 онд 106,2 мянган шоометр хэрэглээний мод, 565,9 мянган шоометр түлээний мод бэлтгэж модны хэрэгцээний тодохой хэсгийг хангасан. 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ойн цэвэрлэгээгээр 750,0 мянган шоометр орчим мод, модон материал бэлтгэж зах зээлд нийлүүлсэн байна.Дээрхи “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” болон тухайн жилд бэлтгэх модны дээд хэмжээг баталсан Сайдын шийдвэрийн дагуу мод, модон материалын хэрэгцээний 92,0-94,0%-ийг ойн цэвэрлэгээгээр бэлтгэж буй мод, модон материалаар хангах ажлыг хэрэгжүүлж хэвшсэн.</p>
2	<p>Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2012.09.21 №02</p>	<p>1.1 Газар тариалангийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгох;</p>	<p>Алслагдсан бүсэд буудайн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, буудайн тариаланг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбуудайн урамшууллыг бүсийн ялгавартайгаар олгох журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 366 дугаар тогтоолоор</p>

			<p>батлуулсан.</p> <p>Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн 62 дугаар тогтоолоор иргэн, хуулийн этгээдийн дотоодын гурилын үйлдвэр болон Тариалан эрхлэлтийг дэмжих сан, улсын нөөцийн салбарт нийлүүлсэн стандартын I ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 55.0 (тавин тав) мянга, II-IV ангиллын шаардлага хангасан хүнсний улаанбуудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 50.0 (тавь) мянган төгрөгөөр олгохоор шийдвэрлүүлсэн.</p> <p>Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2017 онд 726 аж ахуйн нэгж, иргэний 292.4 мянган тонн хүнсний буудайд 14.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.</p>
<p>Нийт 2 тогтоолын 3 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			